

**“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021.04.26-ны өдрийн ээлжит хурлын
тэмдэглэл**

2021.04.26

Улаанбаатар хот

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 сарын 26-ны өдрийн 10 цаг 05 минутанд Zoom <https://zoom.us/> программыг ашиглан /Meeting ID: 991 580 0570 Passcode: 88035811/ нэвтрэн орж хувьцаа эзэмшигчдийн хуралаа эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ш.Амар-Отгон, Нягтлан бодогч О.Ганчимэг хурал зохион байгуулах комиссын гишүүн Н.Батнайрамдал, нар мөн нийт 6 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар, 1 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр оролцов.

Хурлын дарга Ш.Амар-отгон: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа “Хай Би Ойл” ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээсэнийг мэдэгдье.

Ингээд “Хай Би Ойл” ХК-ийн 2021 оны 04 сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулъя. Нийт 52,118,954 хувьцаанаас нийтдээ 89,02% буюу 46,395,813 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдсэн тул хуралаа эхлэж байна.

Өнөөдрийн хурлыг “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Амар-отгон миний бие даргалах бөгөөд хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэг, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлийг өгнө.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Миний бие “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захиралаар 3 дахь жилдээ ажиллаж байгаа Амар-отгон гэж хүн байна. Бид 2020 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцуулна. Би үйл ажиллагааныхаа тайланг ерөнхийд нь танилцуулна. Манай нягтлан бодогч О.Ганчимэг санхүүгийн тайлан, аудитын тайланг танилцуулах болно.

“Хай Би Ойл” ХК нь 2020 оны борлуултын тухайд: 2019 оны түүхий эдийн тосны үлдэгдэл нөөц 251,127 литр, боловсруулсан тосны нөөц /Мазут/ 105,222 литр байсан ба 2020 он гарснаас хойш тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК нь нийт 861,710 л түүхий эдийг байгууллага болон хувь хүнээс цуглуулсан. Өмнөх оны үлдэгдэлтэй нийлээд 1,112,000 литр тосыг цуглуулж, үүнээс 613,972л мазут боловсруулан авч 3 аж ахуйн нэгжид 458,579,414₮ /НӨАТ орсон үнэ/ төгрөгийн үнэ бүхий 582,934л мазутыг борлуулсан байна. Тус борлуултыг 2019 онтой

харьцуулж үзэхэд 344 сая төгрөгөөр бага борлуулт хийсэн буюу 40-45 хувь буурсан. Борлуулалт буурсан нь “Хай Би Ойл ХК”-тай олон жил харилцагч болоод хамтран ажилладаг 3 компанитай гэрээ байгуулан мазутаа нийлүүлсэн боловч цар тахал ковид-19 вирусээс болж тухайн харилцагчдын ажлын гүйцэтгэл багассаны улмаас худалдан авалтын хэмжээ буурсан. Мөн ноднин жил ОХУ-аас мазут маш их орж ирсэн, хувь хүмүүс гар аргаар боловсруулаад хямд үнээр борлуулсан зэргээс борлуулт буурсан тул Мазутын үнээ буулгасан. 9 сараас эхлээд 700 төгрөг болгож бууруулсан. Ингээд 9 сард 152 сая 10 сард 113 сая төгрөгийн борлуулал хийсэн.

2020 оны тайлант хугацаанд түрээсийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой 2 гэрээ, ажил үйлчилгээ үзүүлэх 9 гэрээ, худалдах ба худалдан авахтай холбогдолтой 5 гэрээнүүдийг байгуулсан байна.

2019 онд БОАЖЯ-наас авсан “Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах” үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 1 жилийн хугацаатай олгогдсон байсан нь 2020 оны 7 сард дууссан тул Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах сунгалтын бүрдүүлэх материалуудыг бэлэн болгож БОАЖЯ-манд хүргүүлэн хурлаар орж 5 жилийн хугацаагаар сунгуулан авсан. Бидний үйл ажиллагаа 2 тусгай зөвшөөрөл явагдах ёстой байдаг. Үүний дараагаар Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамнаас Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг авхын тулд Техникийн ашигласан тос дахин боловсруулах” үйлдвэрийн Техник Эдийн Засгийн Үндэслэлийг боловсруулан УУХҮЯ Ашигт Малтмал, Газрын Тосны Газар Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн дүгнэлт гаргуулж батлуулсан. УУХҮЯ-аас олгодог “Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл” эрхлэх тусгай зөвшөөрлийг журмын дагуу зохих материалуудыг бүрдүүлэн өгсөний үр дүнд зөвшөөрөлөө авсан.

“Аюултай хог хаягдал” цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд Байгаль Орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах үүднээс Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр гаргаж, өмнөх оны төлөвлөгөөний биелэлтийг тайлагнадаг.

2020.03.27-нд 2019 оны Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний Биелэлтийн тайлангаа хянуулж, 2020 оны Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө боловсруулж БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газраар баталгаажуулсан.

Дараагын хийгдсэн ажил маань үйлдвэрт хийгдсэн байна. Нэлээн бүтээн байгуулалтын ажилууд хийгдсэн. Харуул хамгаалалтын байр маань үйлдвэрийн гадна хөдөлгөөн орчин тойрныг харах боломжгүйгээр хашаан дотор байрладаг байсан. Манай үйлдвэр маань “Таван толгой” ХК-ийн сайжруулсан түлшний үйлдвэртэй хөрш зэргэлдээ байдаг тул хөл хөдөлгөөн ихтэйгээс үйлдвэрийн хаалга таглаж машинууд зогсох, орц гарцыг хаах асуудлууд гарч бид харуул хамгаалалтыг сайжруулах үүднээс харуулын байрыг компанийн ажилчидаар бариулж худган дээрээ байрлуулан ашиглалтанд оруулсан. Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтэсээс камер тавиулах шаардлага тависан мөн компанид ч хэрэгцээ шаардлага нь байсан учир Үйлдвэрийн дотор болон хашаан доторхи, нийтийн эзэмшлийн талбайг хянах зориулалтаар өмнөх камеруудыг шинэчилж 30 хоног бичлэгээ хадгалах хүчин чадал бүхий 12 ширхэг камераар сольж суурилуулсан.

Авто машин тээврийн хэрэгсэлүүд болох ажилчдын унаа машин (Prado, Starex) болон тосны цистернуудад (Kia Rhino) ээлжит урсгал засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, ЕС зөвшөөрөл, хот дотор явах түр зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн даатгал, татвар, улсын үзлэг, оношилгоонд бүрэн хамруулсан байгаа.

Техникийн хаягдал тос дахин боловсруулахад өдөрт 2тн усыг хөргөлтийн журмаар ашигладаг байсан бөгөөд энэ усаа тусад нь саванд хийж хөргөн дахин ашигладаг байсныг үйлдвэр дотороо нэмж байрлуулан байнгын сэлгэн хөргөдөг болгож өөрчилсөн.

Ноднин 5 сард үйлдвэр эхлэхийн өмнө Үйлдвэрийн тос халаагч тогооны гадаргууд нь гэмтэл гарч шинээр солих шаардлагатай болсон тул иргэн Г.Бямбадоотой гэрээ байгуулж, халаагч тогооны гадна их биеийг нь шинээр хийлгэж суурилуулан, үйлдвэрийн үйл ажиллагааг явуулахад бэлэн болгож хүлээн авсан байгаа.

Үйлдвэрийн барилга дотор үйлдвэрлэлийн тоног төхөөрмжийн нэг хэсэг болох тосны босоо 2 саван дээр агааржуулалтын хоолойг суурьлуулж бэлэн болгосон. “Хай Би Ойл” ХК-ийн Техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу мазут, ус, хөрс, үйлдвэрийн гадна дотно агаар, тоосны шинжилгээнүүдийг хийлгэсэн. Жилдээ 2 удаа өгдөг.

2020 оны 05 сард Мэргэжлийн Хяналтын Газраас “Аюултай хог хаягдал”-ыг дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд төвлөгөөт 56 асуулт бүхий хяналтын хуудсаар шалгалт хийж, эрсдэлийн үнэлгээ тогтооход 2019 онд бидний хийж бүтээсэн багагүй ажлын үр дүнд 15% буюу бага эрсдэлтэй гэсэн үнэлгээ авсан. НМХГ-ын тогтоосон үнэлгээний дагуу хийх ажилд Био 00-г хийж ашиглахыг зөвлөсөний дагуу Био 00, явган зам хийж ашиглалтанд оруулсан.

2020 оны БОМТ-ний дагуу үйлдвэрийн хашаан дотор хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн дагуу мод тарьж, зүлэгжүүлэх, ногоон байгууламжтай болгохоор 20-оод халиас улиас тарьсан. Мөн зам талбайг хатуу хучилттай болгож байна. Агаарт үүсэх тоосжилтоос сэргийлэх мөн хөрсийг хамгаалах чиглэлийн дагуу хашааны доторхи талбайн урд хэсэг, ажилчдын байрны урд талбайг хатуу хучилттай болгож бетондсон. Поошигтой хаягдал тос буулгах хэсгийг бетондож, хөрсний бохирдсон хэсгийн хорыг саармагжуулах ажил хийгдсэн.

Техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан тул үйлдвэрийн галын аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагатай зүйлүүдийг нэмж хийн дүгнэлтийн хугацааг 2 жилээр сунгалт хийлгэсэн.

“Аюултай хог хаягдал” болох техникийн ашигласан тосыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагааг явуулахад юуг анхаарах, ямар журам баримтлах, тухайн ажлын байранд ажилладаг ажилтан нь сургалтанд хамрагдсан байх зэргийг анхаарч нийт ажилчидаа Монголын химич, химийн инженер технологичдын холбооноос явуулдаг Химийн бодис болон аюултай хог хаягдалын талаарх сургалтанд хамруулж сертификаттай болгосон.

Манай компани нь УБ Сонгдо эмнэлэгтэй эрүүл мэндийн үзлэг болон багц шинжилгээ хийлгэх гэрээ байгуулж нийт ажилчдаа 2020 оны 11 дүгээр сарын 10-нд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан байгаа Ажлын байрны үнэлгээ хийлгэсэн байгаа хэдий гэсэн дүнэлт гарсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас найм дахь жилээ зохион байгуулсан. “Ногоон технологи 2020” өдөрлөгт амжилттай оролцож байгаль орчинд хаягдаж болзошгүй Техникийн ашигласан тосыг дахин боловсруулдаг үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмж, боловсруулан гаргаж байгаа M100 маркын мазутыг таницуулж оролцсон. Манай компанийг нефтийн гаралтай хаягдал тосыг дахин боловсруулж, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологийг нэвтрүүлснийг үнэлж “Ногоон гэрчилгээ”-г гэдэг шагналаар шагнуулсан.

Энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар чухал асуудал хэлэлцүүлж байгаа нь компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай байгаа. Одоо байгаа манай дүрмэнд үйл ажиллагааны

чиглэл нь гадаад худалдаа, техникийн тосны үйлдвэрлэл гэсэн бичсэн байгааг “Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах”, Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болгож өөрчлөн дүрмийг шинэчлэн батлуулах байгаа.

Ногдол ашгийн тухайд: ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэрийг танилцуулья аа. Компанийн 2020 оны 12 сарын 31-ны үлдэгдэлээр компанийн дансны үлдэгдэл 35 сая төгрөг байсан. Авлага нь 160 сая төгрөг байсан. Одоогын байдлаар авах авлагаас 38 сая төгрөгөө авсан. Аваад нэг компанийн авлага дууссан. Нэг компанийн үлдэгдэл авлагаа авч чадаагүй байна тус компани төсвөөс мөнгө орж ирээгүй гэх шалтгаан хэлээд байгаа тул хүлээлтийн байдалтай байна. 12 сарын 31 ны дансны үлдэгдэлээр компанийн цаашдийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай урсгал зардал болон гарч болох зардалууддаа болон ирэх ондоо ажиллах бэлтгэл ажилдаа зарцуулах мөнгө байсан учраас ногдол ашиг тараах боломжгүй гэж үзээд ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэр гарсан байгаа шүү.

“Хай Би Ойл” ХК-ийн нягтлан О.Ганчимэг: “Хай Би Ойл” ХК-ийн нягтлан О.Ганчимэг байна. Хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье. Манай компани 2020 онд нийт борлуулалт нь 416,3 сая төгрөгийн борлуулт хийсэн. Цар тахлын улмаас нийт харилцагч компаниудын маань гүйцэтгэх ажилууд нь хойшлогдсоны улмаас худалдан авах чадвар муудсан тул борлуулалт маань өмнөх жилүүдээс буурсан үзүүлэлттэй байгаа. Сүүлдээ мазутынхаа үүнийг бууруулж ажилласан. Одоогоор 124 сая төгрөгийн авлага нь “Дэвжих-эрдэнэ” ХК-аас авна. Борлуулалтын нийт өртөг 376,1 сая төгрөг байна. Ерөнхий удирдлагын зардал 172,9 сая төгрөг байна. Санхүүгийн тайлангын бусад орлого гэдэг дээр 504,7 сая төгрөг байгаа энэ нь найдваргүй авлагын буцаалтаас үүссэн орлогууд байгаа юмаа. Зардалд бүртгэсэн байсан 1. ТУЗ-ын цалингийн зардал 129,1 сая төгрөг 2016 оны 09 сар хүртлэх цалингийн өглөгө байсан. 2.Найдваргүй авлагын нөөц байгуулаад бүртгэсэн байсан “Шарын гол” ХК-тай холбоотой үүссэн орлого байгаа юм. Энэ нь “Шарын гол” ХК-тай байгуулсан шүүхээр эвлэрсэн эвлэрэлийн гэрээн дээр заасан 2.282,9 сая төгрөгийг бүрэн төлж барагдуулна гэснийг үндэслээд найдваргүй авлагын хасагдуулгын буцаалтаас үүссэн 308,8 сая төгрөгийг буцаалтын орлого болгож бүртгэсэн байгаа. 3.Орлогын албан татварын чөлөөлтэй холбоотой үүссэн 60,3 сая төгрөг байгаа юм. Энэ 3-ийн нийлбэр нь 504,7 сая байгаа бөгөөд санхүүгийн тайланд бусад орлого дээр бүртгэсэн байгаа. Дээрх дүн нь орлого олсон гэж харахаар байгаа тул тайлбарлаж байна. Бусад ашиг алдагдал дээр 1.678,9 сая төгрөг харагдаж байгаа үүний 1.636,9 сая төгрөг нь Сингапурын хөрөнгө оруулалт хийсэн Благтип энерги лимитэд компани татан буугдсантай холбоотой үүссэн алдагдал байгаа юмаа. Татан буугдахдаа Хай Би Ойл ХК-д хөрөнгө хувиарлагдахгүй гэсэн тул Хөрөнгө оруулалтыг алдагдалаар бүртгэсэн байгаа. Бараа материалын талаар хэлхэд мазутын үлдэгдэл маань 137,2 литр байна. Түүхий эд буюу хаягдал тосны үлдэгдэл маань 480,9 литр байна. Авлагын талаар гэхээр “Шарын гол” ХК-тай эвлэрэлийн гэрээ байгуулсан байгаа зээл зээлийн хүүгийн үлдэгдэл 2.282,9 сая төгрөг байна. Бусад авлага дээр 39,1 сая төгрөг байна. Мөн “Ашидмөнхийн зам” ХХК-аас авах 108,7 сая төгрөгийн авлагыг найдваргүй авлага үүсгээд явж байна. Өглөгийн тал дээр “Си Би Эм” ХХК-д 77,4 сая төгрөгийн өглөгтэй мөн тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр 56 сая төгрөг байна. 2020 онд хөрөнгийн дахиэ үнэлгээ хийлгэсэн. Өмчийн өөрчлөлт дээр газар эзэмших эрхийг үнэлээд санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгэсэн байгаа.

Хурлын дарга Ш.Амар-отгон: Энэ жилийн аудит компани бол нэлээн нягт нарийн шалгасан байналээ. Финайяда ХХК-аар үнэлгээний тайлан гаргуулсан. 2020 оны 12 сарын 31-ний байдлаар “Хай Би Ойл” ХК-ийн үнэлж буй хөрөнгийн бодит үнэ цэнийг 2,075,982,449 гэж

үнэлсэн. Энэ үнэлгээнд нийт 28 нэр бүхий эд хөрөнгөд үнэлгээ хийсэн. 28 эд хөрөнгөд юу юу орсон гэхээр Газар, Барилга байгууламж, зөөврийн байр сууц, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл гэх мэт орсон байгаа. Аудитын дүгнэлтээр санхүүгийн тайланд 10 залруулга хийх шаардлагатай байна гэсэн тул тус аудитын компаниар залруулгыг хийлгэн холбогдох хороо, бирж, санхүүд өгсөн байгаа. Тус 10 залруулгад юу юу багтаж байна гэхээр 2019 онд бүртгэх ёстой өрийг 2020 онд бүртгэсэн, Газар эзэмших эрхээ үүсгээд бүртгээгүй байсаныг бүртгэсэн, халаасны хувьцааг хөрөнгө оруулалт гэж буруу бүртгэсэн, хойшлогдсон татварын өглөгийг зөв дүнгээр бүртгээгүй 78 сая гэж бүртгэсэн байсан бодитоор 60,3 сая байсан, Сингапурын татан буугдсан Блэктип энерги лимитэд компанийн 1.636,9 -ийг гарзаар бүртгээд балансаас хасаад явсан байгаа, ТУЗ-ын гишүүдийн цалингын 129 сая төгрөгийн өрийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан, олгохгүй гэж шийдсэн тул өргүй гэж үзээд буцаагаад орлогоор бүртгэсэн байгаа, төнөг төхөөрөмж дээр үл хөдлөхийн гэрчилгээ гаргуулаад илүү татвар төлөөд явсан байна 2008 оноос хойш. Тоног төхөөрөмж үл хөдлөх хөрөнгө бишээ татвар илүү төлсөн байна гэсэн, “Шарын гол” ХК-ийн өр дээр БДО аудитын компаниар аудит хийлгэж байх явцад 25 хувиар найдваргүй авлага болох магадлалтай гэж үзээд найдваргүй авлагын нөөцийн сан үүсгээд тэрэндээ бүртгээд явсан, авлагаа зөв ангилж бүртгээгүй байсан, мөн сангын яамнаас өгдөг кодоо буруу кодоор бүртгэсэн гэх мэт зүйлүүд байна гэсэн. Дээрх 10 залруулга аудитын компаниараа хийлгээд одоо санхүү тайлан балансын хувьд жигдрээд асуудалгүй болсон гэж үзэж байгаа. Дээрх тайланг хийсэн нягтлан бодогч Б.Бадамханд нь 2021 оны 03 сарын 31нд ажилаас чөлөөлөгдсөн байгаа. Одоо нягтлан бодогчоор О.Ганчимэг ажиллаж байна. Компани маань одоо 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

ТУЗ-ийн нарийн бичиг Н.Батнайрамдал: За дээрх үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангаас асуух зүйл байна уу.

Хурлын дарга Ш.Амар-отгон: “Шарын гол” ХК-аас авах авлагатай холбоотой шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлхээр Дархан-уул аймгийн шүүхийн шийдвэрт өгсөн байгаа. “Шарын гол” ХК-д мэдэгдэл өгсөн байгаа гэсэн хариу авсан. Бид энэ жилийн ажилаа 3 сарын 15 наас нэлээн эрттэй эхлээд явж байсан боловч цар тахлаас болоод 2 удаа ажил зогсчлоо. Одоо 5 сарын 8 наас эхлээд ажил эхлэх юм бол түүхий эдийн нөөц сав дүүрсэн байгаа, мазут бүтээгдэхүүн маань гархад бэлэн болсон байгаа. Энэ жил байнгын харилцаж байгаа 3 компанитайгаа гэрээ байгуулхаар бэлдсэн байгаа гэхдээ яг гэрээгээ зураагүй байна. Эхний нэг компани маань 5 сарын 5 нд Хэнтий аймагруу мазутын таталт хиймээр байна гэсэн одоогийн нөхцөл байдалд гаргаж чадах үгүйгээ мэдэхгүй байна. Аль болох ажилдаг 6 сардаа үр өгөөжтэй үр бүтээлтэй ажиллахаар хичээж байна.

Хувьцаа эзэмшигч “Бидисек ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Б.Даваадорж: 2021 оны ажлын төлөвлөгөө нь ямархуу чиглэлээр байгаа вэ. Жоохон чиглэл өгөөч

“Хай Би Ойл” ХК-ийн нягтлан О.Ганчимэг: Ерөнхийдөө Байгаль орчны яамнаас чиглэл өгсөн байдаг түүнийхээ дагуу хийгдэх ажилуудаа тусгадаг. Одоо хөрсний талаас гэхэд дахин мод тарих, Богдхан ууланд хэсэгхэн газар 2,5 сая төгрөгөөр мод тарихаар төлөвлөгөөндөө оруулсан байгаа үйлдвэрт хөрс шороогоо хамгаалах үүднээс талбайгаа бетонжуулах ажилууд хийгдхээр байгаа, найман ширхэг агуулах савыг будаж, номержуулах, үйлдвэрийн хашаан дотрох гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, хамгийн чухал нь борлуулалтаа нэмэгдүүлэх ажил байна. Мөн танилцуулга самбар хадах, компани өөрийн гэсэн вэб сайттай болхоор тус тус төлөвлөж ажиллаж байна.

Хурлын дарга Ш.Амар-отгон: Манайхтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулхаар энэ жил 3 компани зөвшөөрөлөө авсан өрсөлдөгч компаниуд гарч ирж байгаа тул борлуулалтан дээрээ нэлээн хичээж ажиллахгүй бол болохгүй байна. Мөн хажуугаар нь зөвшөөрөлгүй гар аргаар хувь хүмүүс хийгээд байна. Хууль бусаар мазут үйлдвэрлээд байгаа хүмүүсийг эклогын цагдаа албанд мэдэгдсэн гэж хог хаягдлын холбоо маань хэлж байсан. Мөн ажилласан масло авч хэрэглээд байгаа газрууд бас байна. За ингээд тооллогын гишүүдээс ирсэн саналал хураалтын дүнгээ танилцуулая.

Хурлын төгсгөлд хурлын дарга Ш.Амар-отгон тооллогын гишүүдээс ирсэн санал хураалтын дүнг танилцуулав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 89,02 % буюу 46,395,813 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс 89,02 % буюу 100% хүчинтэй байлаа.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 99 % нь зөвшөөрсөн, 1 нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

2. Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

3. Компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс **Б.Лхагвадорж 14,53%, Т.Батгэрэл 17,09%, Б.Дөлгөөнтамир 17,09%, С.Одгэрэл 17,09%, Б.Пүрэвбаатар 17,09%, Р.Оюунбат 17,09%-** ийн санал авч ердийн гишүүдэд сонгогдлоо.

Хараат бус гишүүдэд **А.Харцага 25,59%, Т.Тамир 25,59%, Ж.Болорцэцэг 25,59%-** ийн саналтайгаар сонгогдлоо.

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны хуралд маань цаг заваа гарган оролцсон та бүхэндээ баярлалаа. Энэ 2021 ондоо ковид-19 гэж шалтаг шалтгаан тоочилгүй чадах хэмжээгээрээ боломж нөөц боломжоороо хичээн зүтгэж ажиллах болно. Энэ жил хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг тараахын төлөө хичээж ажиллах болноо гэдгийг хэлмээр байна.

Хурал 11:20 өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:



Ш.Амар-отгон Ш.АМАР-ОТГОН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Н.Батнайрамдал Н.БАТНАЙРАМДАЛ